БАТЛАВ:
ШУТИС-ИЙН ХҮНС, ХӨНГӨН ҮЙЛДВЭРЛЭЛ, ДИЗАЙНЫ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ

.....Н.ГАНЗОРИГ
2026 оны ..... сарын ..... өдөр

БАТЛАВ:
ПРЕМИУМ НЕКСУС ХК-ИЙН ХУДАЛДАА ЭРХЭЛСЭН ЗАХИРАЛ

.....Ц.НОМИНЗОЛ
2026 оны ..... сарын ..... өдөр

“АЯ ТУХТАЙ ДЭЛГҮҮРИЙН ШИНЭ ХООЛ”
ОЮУТНЫ БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

1. ЗОРИЛГО

CU ая тухтай дэлгүүрийн сүлжээ нь өдөр бүр шинээр үйлдвэрлэгдсэн сэндвич, бургер, салат, кимбаб, онигири, савтай хоол, шөл зэрэг 100 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг 635 гаруй салбараараа дамжуулан хэрэглэгчдэд хүргэж байна.

Уралдааны зорилго нь савтай хоолны ангилалд оюутнуудын дунд бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн уралдаан зохион байгуулж, шинэлэг санаа, багийн ажиллагаа, гүйцэтгэлийн үр дүнгээр шалгарсан бүтээгдэхүүнийг CU ая тухтай дэлгүүрт нэвтрүүлэн худалдаанд гаргах, ингэснээр их сургууль ба үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг бэхжүүлж, оюутнуудын мэргэжлийн ур чадварыг бодит ажлын орчинд хөгжүүлэхэд оршино.

2. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

- ШУТИС-ийн Хүнс, хөнгөн үйлдвэрлэл, дизайны сургууль
- Премиум Нексус ХК (CU брэндийн эзэмшигч)

Хамтран ажиллагч: Сэнтрал Фүүдс ХХК (хоолны үйлдвэр)

3. ОРОЛЦОГЧИД

- ШУТИС-ийн Хүнс, хөнгөн үйлдвэрлэл, дизайны сургуулийн бакалавр, магистр болон докторын түвшний оюутнууд оролцоно.
- Баг нь 3-5 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд нэг гишүүнийг багийн ахлагчаар томилно.
- Нэг оюутан зөвхөн нэг багт оролцоно.
- Баг нь сургуулийн багш нараас зөвлөх багш сонгож болно.

4. ХУГАЦАА БОЛОН ҮЕ ШАТ

Уралдаан 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэл дараах үе шаттай явагдана.

№	Үе шат	Хугацаа	Байршил/ хэлбэр
1	Бүртгэл	2026.10.12	research_sflid@must.edu.mn хаягаар цахимаар

2	Үйлдвэртэй танилцах	10/19 (Даваа) - 10/23 (Баасан)	Хонхорт байрлах хоолны үйлдвэр (багуудын хуваарийг бүртгэл дууссаны дараа мэдэгдэнэ).
3	Бүтээгдэхүүн хөгжүүлэлт, туршилт	10/12 - 11/17	Баг тус бүр бие даан, шаардлагатай тохиолдолд зөвлөгөө авна.
4	Ментортой зөвлөлдөх уулзалт	11/9 (Даваа) -11/13 (Лхагва)	Баг тус бүр өөрсдийн хөгжүүлсэн бүтээгдэхүүнд зөвлөгөө авна.
5	Уралдааны материал хүлээн авах	11/18 (Лхагва) 17:00 цаг хүртэл	research_sflid@must.edu.mn хаягаар цахимаар
6	Шалгаруулалт, шагнал гардуулах	11/20 (Баасан) 15:00 цаг	ХХҮДС-ийн 1-337 тоот танхим

5. УРАЛДААНЫ ХҮРЭЭНД ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

5.1. Судалгаа ба төлөвлөлт

- CU ая тухтай дэлгүүрт худалдаалагдаж буй савтай хоолны нэр төрөл, зах зээлийн байдалд судалгаа хийж, дутагдаж буй орон зай болон зорилтот хэрэглэгчийг тодорхойлно.
- Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн төлөвлөгөөг шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх төлөвлөлтийн хуудсанд бөглөнө (Хавсралт 2).
- Хонхор дахь хоолны үйлдвэртэй танилцаж, үйлдвэрлэлийн технологи, тоног төхөөрөмж, хязгаарлалтын талаарх мэдээлэл авна.

5.2. Бүтээгдэхүүн хөгжүүлэлт

- Зохион байгуулагчаас баг бүрт савлагааны дээж олгох бөгөөд хөгжүүлсэн бүтээгдэхүүнээ тухайн сав баглаа боодолд тохируулан савлана.
- Бүтээгдэхүүний шим тэжээлийн үзүүлэлт (илчлэг, уураг, өөх тос, нүүрс ус, давс) нь нэг удаагийн хоолонд ногдох зөвлөмж хэмжээнд нийцсэн, тэнцвэртэй байна.
- Түүхий эд нь Монгол Улсад тогтвортой нийлүүлэгдэх боломжтой, бүтээгдэхүүн нь хүйтэн хэлхээнд (0-5°C) хадгалагдаж, богино хугацаанд чанараа алдахгүй байх шаардлагыг харгалзана.
- Технологи карт боловсруулж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх зааварчилгааг бэлтгэнэ.

5.3. Шошго, эдийн засгийн тооцоо

- Бүтээгдэхүүний онцлогт тохирсон, зорилтот хэрэглэгчдэд чиглэсэн загвар дизайнтай шошгыг боловсруулна. Шошгоны мэдээлэл нь “Хүнсний тухай хууль”, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль” болон холбогдох стандартын шаардлагыг бүрэн хангана (нэр, найрлага, харшил үүсгэгч, шим тэжээлийн үзүүлэлт, цэвэр жин, хадгалах нөхцөл, хадгалах хугацаа гэх мэт).
- Бүтээгдэхүүний өртгийн тооцоо хийж, борлуулах үнэ болон борлуулалтын тооцооллыг/төлөвлөгөөг гаргана (Хавсралт 3).

5.4. Шалгаруулалтын өдөр

- Баг бүр 10 хүртэлх минутын илтгэл тавьж, 5 минутын хугацаанд шүүгчдийн асуултад хариулна.

- Хөгжүүлсэн бүтээгдэхүүнээ савлагаанд савласан бэлэн байдлаар, шүүгчдийн амталгаанд хүрэлцэхүйц хэмжээгээр (дор хаяж 3 ширхэг) авчирч танилцуулна.
- Дээжийг шалгаруулалтын өдөр буюу өмнөх өдөр нь эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд бэлтгэсэн байна.

6. ИРҮҮЛЭХ МАТЕРИАЛ

Баг нь 2026 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 17:00 цагаас өмнө дараах материалыг нэг цахим шуудангаар, "Багийн нэр - Уралдааны материал" гэсэн гарчигтайгаар research_sflid@must.edu.mn хаягаар ирүүлнэ:

1. Хавсралт 2 - Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх төлөвлөлтийн хуудас;
2. Хавсралт 3 - Өртөг, үнийн болон борлуулалтын тооцоо;
3. Зах зээлийн судалгааны товч тайлан (судалгааны арга, үр дүн, дүгнэлт);
4. Бүтээгдэхүүний технологи карт, үйлдвэрлэлд нэвтрүүлэх зааварчилгаа;
5. Шошгоны загвар (эх файл болон хэвлэх хэлбэрээр);
6. Танилцуулга (PPT/PDF, 10 хүртэлх минутын илтгэлд зориулсан).

Хугацаа хэтэрсэн, бүрдэл дутуу материалыг үнэлгээнд оруулахгүй.

7. ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Шүүгч бүр багийг 100 оноогоор дүгнэх ба багийн эцсийн оноог шүүгчдийн өгсөн онооны дунджаар тооцно. Оноо тэнцсэн тохиолдолд "Амт чанар" шалгуурын оноо өндөр багийг дээгүүр байранд эрэмбэлнэ.

№	Шалгуур	Үнэлэх үзүүлэлт	Оноо
1	Зах зээлийн судалгаа	CU-ийн савтай хоолны нэр төрлийн дутагдаж буй орон зайг тодорхойлсон байдал, зорилтот хэрэглэгч, судалгааны арга зүй, дүгнэлтийн үндэслэл	20
2	Амт чанар	Амталгааны үр дүн (амт, үнэр, бүтэц, өнгө), бүтээгдэхүүний чанар, хадгалалтын явцад чанараа хадгалах чадвар	25
3	Бүтээгдэхүүний дизайн, найрлага, шошго	Харагдах байдал, орц найрлага, нэг порцын хэмжээ, шим тэжээлийн тэнцвэр, савлагаанд тохирсон байдал, шошгоны дизайн ба хууль эрх зүйн шаардлагад нийцсэн байдал	20
4	Шинэлэг байдал	Санааны шинэлэг, өвөрмөц байдал, зах зээлд байгаа бүтээгдэхүүнээс ялгарах онцлог	10
5	Үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломж, эдийн засгийн үндэслэл	Технологи картын бүрэн байдал, үйлдвэрийн нөхцөлд үйлдвэрлэх боломж, өртөг, борлуулах үнэ, ашигт ажиллагааны тооцоо	15
6	Багийн ажиллагаа ба илтгэл	Гишүүдийн оролцоо, үүрэг хуваарилалт, танилцуулгын чанар, асуултад хариулсан байдал	10
	НИЙТ		**100**

8. ШАГНАЛ

Байр	Тоо	Шагнал
Тэргүүн байр	1 баг	10,000,000 төгрөгийн мөнгөн шагнал, өргөмжлөл, бүтээгдэхүүнээ CU-д нэвтрүүлэх эрх
Дэд байр	1 баг	5,000,000 төгрөгийн мөнгөн шагнал, өргөмжлөл, бүтээгдэхүүнээ CU-д нэвтрүүлэх эрх
Тусгай байр (Шинэлэг санаа)	3 баг	Тус бүр 2,000,000 төгрөгийн мөнгөн шагнал, өргөмжлөл
Нийт шагналын сан	**5 баг**	**21,000,000 (хорин нэгэн сая) төгрөг**

Тусгай байрыг "Шинэлэг байдал" шалгууруар хамгийн өндөр оноо авсан, тэргүүн болон дэд байрт шалгараагүй багуудад олгоно. Бүх оролцогчид оролцсоны сертификат олгоно.

9. ОЮУНЫ ӨМЧ, БУСАД НӨХЦӨЛ

- Шалгарч шагнал авсан бүтээгдэхүүний жор, технологи, шошгоны загвартай холбоотой оюуны өмчийн эрх нь Премиум Нексус ХК-д шилжинэ. Бүтээгдэхүүнийг худалдаанд гаргахдаа хөгжүүлсэн багийн нэрийг танилцуулга, сурталчилгаанд дурдана.
- Шалгараагүй багуудын бүтээл тухайн багийн өмч хэвээр байна.
- Оролцогчид бусдын бүтээл, жор, загварыг хуулбарлахгүй байх ба зөрчил илэрсэн тохиолдолд уралдаанаас хасна.
- Уралдаанд оролцох явцад олж авсан үйлдвэрлэлийн болон худалдааны мэдээллийг гуравдагч этгээдэд задруулахгүй.

10. ХОЛБОО БАРИХ

Уралдааны зохион байгуулалттай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг дараах хаягаас лавлана уу:

ШУТИС-ийн Хүнс, хөнгөн үйлдвэрлэл, дизайны сургууль
Цахим шуудан: research_sflid@must.edu.mn
Утас: 99046148; 94049944

Хавсралт 1

“АЯ ТУХТАЙ ДЭЛГҮҮРИЙН ШИНЭ ХООЛ” УРАЛДААНЫ БҮРТГЭЛИЙН МАЯГТ

Багийн нэр: .....

Зөвлөх багш (овог, нэр, утас): .....

Бүтээгдэхүүний санаа (товч, 1-2 өгүүлбэр):

.....

.....

.....

.....

.....

Багийн гишүүд

№	Овог, нэр	Хөтөлбөр / түвшин	Курс	Оюутны код	Утас	Цахим шуудан
1 (ахлагч)						
2						
3						
4						
5						

Бөглөсөн маягтыг 2026 оны 10 дугаар сарын 12-ний өдрийг дуустал research_sflid@must.edu.mn хаягаар ирүүлнэ үү.

Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн төлөвлөгөө

Бүтээгдэхүүний нэр		Төлөвлөгөө гаргасан	
Багийн нэр		Өмнөх шинэчлэл	

■ Шинэ бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл

1. Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн үндэслэл

Шинээр бүтээгдэхүүн /Үүнийг дагаж хөгжүүлэх/	Бүтээгдэхүүний нэр:		
	Харагдах байдал, онцлога	Нэр төрөлжөлт	Ялгарал
Зураг			

Зах зээлийн тренд, үндэслэл	

2. Өрсөлдөгчийн болон зах зээлийн судалгаа

	Бүтээгдэхүүний модэлэл	Тайлбар
Өрсөлдөгч 1		
Өрсөлдөгч 2		
Зах зээлийн дунаж		

4. Хөгжүүлэлтийн хугацааны төлөвлөгөө (6-8 Week)

Эхлэх	Дуусах	Бүтээгдэхүүн нэвтрүүлэх

5. Хөгжүүлэлт харнуулсан баг

Багийн нэр	Нэр	Гүйцэтгэх үүрэг, харнуулан ажил	Тайлбар

■ Маркетингийн стратеги

1. STP стратеги

Segmentation /Сегментчлэл/	Targeting /Зорилтот хэрэглэгч/	Positioning /Байршуулалт/
		1. Concept 2. Product value 3. Price range

2. 4P маркетингийн холцын талмаглал

Product - Бүтээгдэхүүн

Нэршил	Сав багтаа боодол	Брэнд	Хэмжээ	Онцлог байдал /characteristic/
		CU cnts		

Price - Үнэ

Нэр	Төлөвлөсөн үнэ	Өртөг	Ашгийн маржин	Хэлэлцэх буй одрийн борлуулалтын оноо

Promotion - Идэвхжүүлэлт

Идэвхжүүлэлтийн төсөв:

Дэлгүүрийн үйл ажиллагаа дэмжих	Хэрэглэгчид зориулсан урамшуулал	Хөтөлбөртэй эсэх

Place-Байршуулалт

Салбарт өрөх байршил	Хэрэглэгчид зориулсан урамшуулал	Тайлбар

Хөргүүрийн хоолны санал хүлээн авах хуудас

Бүтээгдэхүүний нэр:

Өртгийн задаргаа:

Шууд материалын зардал		Шууд хөдөлмөрийн зардал тооцсон гарц /Тоо/ш/	
Сав баглаа боодлын материалын зардал /Савалгаа+Шошго гэх мэт/		Нэгж бүтээгдэхүүнд ногдох үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал /Тог, ус, дулаан/	
Шууд хөдөлмөрийн зардал		Нийлүүлэх өртөг үнийн санал /НӨАТ-тэй/	

Орц, найрлагын мэдээлэл:

№	Орцын нэр	Эх үүсвэр/нийлүүлэгч байгууллага	Хэмжих нэгж	Нэгж бүтээгдэхүүнд орж буй бохир жин	Нэгж бүтээгдэхүүнд орж буй цэвэр жин /Дулааны боловсруулалтын дараагаарх/	Орц материалын 1кг-ийн үнэ /хуучин үнэ/	Нэгж бүтээгдэхүүнд эзлэх өртөг үнэ / Бохир жингээрх/
1							
2							
3							
4							
5							
6							
7							
8							
9							
10							
11							
12							
13							
14							
15							
16							
17							
18							
19							
20							
21							
				Нийт жин		Нийт материалын өртө	-